

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэшиг сумын Ойн ангийн 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд
хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2024/55/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Булган аймаг
2024 он

Дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Энхтөр
Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 38

танай _____ ны № _____ т

ТЭШИГ СУМЫН ОЙН АНГИЙН
ДАРГА Г.СҮХБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын Ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тэшиг сумын Ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд урсгал үйл ажиллагааны орлогоос 3.01 сая төгрөг, өөрийн орлого 39.7 сая төгрөг, урьд оны авлага 4.6 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 52.1 сая төгрөг зарцуулсан байна.

Тэшиг сумын Ойн анги нь гүйцэтгэлийн төлөвлөөгөөр 10 арга арга хэмжээг төлөвлөж биелэлтийг 95 хувиар дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд

006020230

ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	7,793,190.89	2,360,838.03
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,399,800.00	4,779,850.00
Нийт хөрөнгийн дүн	12,192,990.89	7,140,688.03
Нийт өр төлбөрийн дүн		
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	12,114,990.29	7,140,688.03
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	12,192,990.89	7,140,688.03
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	30,530,000.00	44,447,830.00
Үйл ажиллагааны зардлын дүн	22,202,726.59	49,422,132.26
Үйл ажиллагааны үр дүн	8,327,273.41	(4,974,302.26)
Үйл ажиллагааны бус үр дүн		1,099,950.00
Үйл ажиллагааны нийт үр дүн	8,327,273.41	(4,974,302.26)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		12,114,990.29
Тайлант оны үр дүн		(4,974,302.26)
Эцсийн үлдэгдэл		7,140,688.03
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	28,535,185.00	49,062,535.00
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	22,293,126.59	48,357,175.55
Үйл ажиллагааны ЦМГ	6,242,058.41	705,359.45
Хөрөнгө оруулалтын ЦМГ	4,399,800.00	1,480,000.00
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	1,842,258.41	(774,640.55)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,010,085.29
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,235,444.74
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		49837175.55
Урсгал зардал		48357175.55
Хөрөнгийн зардал		1,480,000.00
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		49,062,535.00
Улсын төсвөөс санхүүжих		
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		49,062,535.00

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.09 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 0.09 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Тээвэр шатахууны зардлаас 0.09 сая төгрөгийг зарцуулсан боловч 59-86 УЕК дугаартай авто машин бүртгэлгүй дугаар дээр замын хуудас бичсэн. 90-86 УБХ дугаарыг андуурч замын хуудас бичсэн тул залруулав.

Аудитаар нийт 64.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 0.05 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 0.01 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт-1:

53-12БУЛ улсын дугаартай дизель Ланд-80 авто машинд 0.05 сая төгрөгийн АИ92 бензин зарцуулсан. (smartcar-аар системээр шалгаж үзэхэд дизель авто машин)

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэж шийдвэрлэсэн.

5.2 Албан шаардлага хүргүүлээгүй

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт-1:

Цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварыг илүү олгосон 0.01 сая төгрөгийн авлагыг барагдуулах.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцээгүй.

Илрүүлэлт-2:

Талбай тусгаарлалтын 26 гэрээний 170 га талбайг тусгаарласан анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэсэн заалттай нийцээгүй.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулс ан		Буруу тусган илэрхийлсэ н		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулс ан		Залруулааг үй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тэшиг сумын Ойн анги	1	0.09					1	0.09				
Дүн	1	0.09					1	0.09				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Тэшиг сумын Ойн анги	1	0.05	1	0.05								
Тэшиг сумын Ойн анги	2	0.01					2	0.01				
Дүн	3	0.06	1	0.05			2	0.01				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						